



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/228

Есөнбулаг сум

Ой тэмдэглэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журмын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шарга сумын Ерөнхий боловсролын сургуулийн тэмдэглэлт 90 жилийн ойг 2026 оны 08 дугаар сарын 01, 02-ны өдрүүдэд зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Ойн арга хэмжээг зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөн тусалж, хамтарч ажиллахыг аймгийн Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т, бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан, чанарын өндөр түвшинд зохион байгуулахыг Шарга сумын Засаг дарга (Д.Батцагаан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

